



**БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2015 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 01/112

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 зүйлийн 29.2, Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийг, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Булган аймгийн Булган сумын Зүүн түрүүний голын төмөр бетон гүүр барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны 2015 оны 03 сарын 11-ны өдрийн зөвлөмжийн дагуу Булган аймгийн Булган сумын Зүүн түрүүний голын төмөр бетон гүүр барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын “ЗМЗ” ХХК-ийг сонгон 393607748 /Гурван зуун ерин гурван сая зургаан зуун долоон мянга долоон зуун дөчин найман / төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгосугай.

2. Гэрээт ажлын санхүүжилтийг хууль журмын дагуу 2015 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас 184 207 784 /Нэг зуун наян дөрвөн сая хоёр зуун долоон мянга долоон зуун наян дөрвөн төгрөг/, авто замын сангийн хөрөнгө оруулалтаас 209 400 000 / Хоёр зуун есөн сая дөрвөн зуун мянган төгрөг/ санхүүжүүлэхийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс / Д.Батцогт/-г зөвшөөрсүгэй.

3. Гэрээнд заасан Булган аймгийн Булган сумын Зүүн түрүүний голын төмөр бетон гүүр барих ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг “ЗМЗ” ХХК /Д.Ганбаатар/-д даалгасугай.

4. Дээрх аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Аймгийн Засаг даргын Тамгын газар Хөгжлийн бодлогын хэлтэс /А.Ганболд /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ЭРДЭНЭБАТ